

СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын Хайлааст голомт ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СБА-2022/13/НА-СТА-ОНА

Цахим хуудас:

www.audit.mn

Улаанбаатар хот

2022 он

Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: М.Нарантуяа

Утас: 70518396 Цахим хаяг: narantuyam@audit.gov.mn

Аудитын менежер:

Утас: 70512123 Цахим хаяг: davaag@audit.gov.mn

Аудитор:

Утас: 70512127 Цахим хаяг: altansukhe@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
3. Аудитын тайлан.....	7
3.1 Ерөнхий зүйл.....	7
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	7
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	8
3.4 Материаллаг байдал	8
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	8
Байгууллагын үйл ажилагаа	8
Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин	9
3.6 Нягтлан бодох бүртгэлийн бодлого.....	9
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	11
3.8 Аудитын гол асуудал	11
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	11
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	11
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	11
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	11
4. Аудитын илрүүлэлт	12
4.1 Зөвлөмж.....	12
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	13
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар



**СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс: 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

2022.03.16 № 139
танай _____-ны № _____-т

ХАЙЛААСТ ГОЛОМТ ОНӨААТҮГ-ЫН
ЗАХИРАЛ Б.СОДНОМЦЭРЭН
ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хайлааст голомт ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Хайлааст голомт ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Байгууллагын удирдлага санхүүгийн тайлан, тодруулгыг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.НАРАНТУЯА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	БАЛАНСЫН ЗҮЙЛ	2020 оны 12 сарын 31	2021 оны 12 сарын 31
А	Б	1	2
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	91,578,182.30	78,456,596.53
1.1.1.2	Банкин дахь мөнгө	91,578,182.30	78,456,596.53
1.1.2	Дансны авлага	52,360,243.22	74,505,378.16
1.1.2.2	Борлуулалтын авлага	52,360,243.22	74,505,378.16
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	4,188,806.61	901,809.98
	Орлогын татварын авлага	4,188,806.61	901,809.78
1.1.3.2	Орлогын татварын тооцоо	4,188,806.61	901,809.78
1.1.4	Бусад авлага	25,311,449.35	23,976,752.55
1.1.4.1	Хувь хүнээс авах авлага	20,324,667.89	18,989,971.09
1.1.4.2	Байгууллагаас авах авлага	4,986,781.46	4,986,781.46
1.1.6	Бараа материал	12,047,985.26	17,798,883.23
1.1.6.1	Түүхий эд материал	11,309,691.36	15,245,891.36
1.1.6.4	Хангамжийн материал	284,643.90	2,099,341.87
1.1.6.5	Сэлбэг хэрэгсэл	453,650.00	453,650.00
	Эргэлтийн хөрөнгийн дүн	185,486,666.74	195,639,420.46
1.2.1	Үндсэн хөрөнгө	1,103,598,501.71	1,642,673,498.03
1.2.1.1	Газар, газрын сайжруулалт	20,835,200.00	21,179,200.00
1.2.1.2	Барилга байгууламж	848,114,290.00	1,332,077,173.37
1.2.1.3	Хуримтлагдсан элэгдэл. Барилга	-34,576,843.02	-46,192,058.70
1.2.1.4	Машин, тоног төхөөрөмж	409,662,715.00	427,962,715.00
1.2.1.5	Хуримтлагдсан элэгдэл. МТТ	-156,694,230.67	-205,077,931.61
1.2.1.6	Тээврийн хэрэгсэл	9,500,000.00	109,500,000.00
1.2.1.7	Хуримтлагдсан элэгдэл. Тээвэр	-1,187,500.00	-2,612,500.00
1.2.1.8	Тавилга эд хогшил	10,914,700.00	10,914,700.00
1.2.1.9	Хуримтлагдсан элэгдэл. ТЭХ	-4,482,329.60	-5,727,799.60
1.2.1.10	Компьютер, бусад хэрэгсэл	9,439,589.00	9,439,589.00
1.2.1.11	Хуримтлагдсан элэгдэл. Компьютер	-7,927,089.00	-8,789,589.43
1.2.2.3	Компьютер Программ хангамж	500,000.00	500,000.00
1.2.2.4	Хуримтлагдсан элэгдэл. Программ хангамж	-500,000.00	-500,000.00
1.2.1	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,103,598,501.71	1,642,673,498.03
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,289,085,168.45	1,838,312,918.49
2.1.1.2	Цалингийн өглөг	0.76	0.10
2.1.1.3	Татварын өр	4,590,567.62	9,264,267.39
2.1.1.3.1	НӨАТ-ын тооцоо	4,017,828.98	8,706,040.92
2.1.1.3.3	ХХОАТ-ын тооцоо /Суутган-1/	14,513.04	0.00
2.1.1.3.6	Бусад татварын тооцоо	558,225.60	558,226.47
2.1.1.4	НДШ-ийн өглөг	395,551.08	345,095.01
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	767,216,848.35	1,287,238,989.14
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	39,931,115.77	27,327,772.05
2.1.1.1.1	Байгууллагад өгөх өглөг	39,622,170.29	27,026,469.37
2.1.1.1.2	Хувь хүнд өгөх өглөг	308,945.48	301,302.68
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	812,134,083.58	1,324,176,123.69
2.1.2.10	Өр төлбөрийн нийт дүн	812,134,083.58	1,324,176,123.69
2.3.1	Төрийн өмч	559,377,218.00	559,377,218.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	50,346,312.00	50,346,312.00
2.3.6.1	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ	50,346,312.00	50,346,312.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг:	-132,772,445.13	-95,586,735.20
2.3.9.1	Тайлант үеийн ашиг	0.00	37,185,709.93
2.3.9.2	Өмнөх үеийн ашиг	-132,772,445.13	-132,772,445.13
2.3.11	Эздийн өмчийн дүн	476,951,084.87	514,136,794.80
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	1,289,085,168.45	1,838,312,918.49

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1.1	Бараа бүтээгдэхүүн борлуулсны орлого	231,290,137.95	268,289,809.09
2	Борлуулалтын өртөг		
2.1	Борлуулсан бараа, бүтээгдэхүүний өртөг	217,838,005.26	222,345,703.93
-	Шууд материалын зардал /ТЭМЗ/	80,865,245.64	64,645,624.00
-	Ажиллагчдын цалингийн зардал	45,082,356.16	42,304,646.23
-	ААН-ээс төлсөн НДШ-ийн зардал	7,390,218.08	6,709,727.67
-	Албан татвар, төлбөр, хураамж		282,540.00
-	Шуудан холбооны зардал		143,454.55
-	Ашиглалтын зардал	28,493,945.58	25,031,440.83
-	Засварын зардал	8,982,500.00	629,800.00
-	Элэгдэл, хорогдлын зардал	36,840,822.53	62,286,416.62
-	Цэвэрлэгээ үйлчилгээний зардал	6,024,350.00	2,417,672.73
-	Шатахууны зардал		6,449,290.91
-	Бусад зардал	4,158,567.27	11,445,090.39
3	Нийт ашиг /алдагдал/	13,452,132.69	45,944,105.16
5	Хүүгийн орлого	16,303,311.77	8,447,488.58
8	Бусад орлого		48,472,967.94
	Бусад орлого		48,189,342.58
	Үйл ажиллагааны бус орлого		283,625.36
10	Ерөнхий ба удирдлагын зардал	48,865,783.77	59,822,576.50
-	Ажиллагчдын цалингийн зардал	32,157,255.40	37,299,790.64
-	ААН-ээс төлсөн НДШ-ийн зардал	4,154,542.17	5,216,018.80
-	Албан татвар, төлбөр, хураамж		760,273.97
-	Томилолтын зардал	257,500.00	268,000.00
-	Бичиг хэргийн зардал	236,100.00	94,218.18
-	Шуудан холбооны зардал		702,363.64
-	Засварын зардал	290,000.00	0.00
-	Элэгдэл, хорогдлын зардал	1,104,677.67	1,245,470.00
-	Түрээсийн зардал	5,640,000.00	5,640,000.00
-	Цэвэрлэгээ үйлчилгээний зардал	450,000.00	4,241,844.00
-	Шатахууны зардал	3,262,910.00	3,630,218.18
-	Бусад зардал	1,312,798.53	724,379.10
11	Санхүүгийн зардал	3,365,398.00	1,724,529.70
-	Хүүгийн зардал	3,365,398.00	1,724,529.70
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-18,860,408.22	41,317,455.48
19	Орлогын татварын зардал	1,630,331.18	4,131,745.55
-	Тайлангийн үеийн орлогын татварын зардал	1,630,331.18	4,131,745.55
20	Татварын дараах ашиг (алдагдал)	-20,490,739.40	37,185,709.93
22	Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал/	-20,490,739.40	37,185,709.93
24	Орлогын нийт дүн	-20,490,739.40	37,185,709.93

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

ᠮᠣᠷᠢᠨ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	ᠣᠳᠣᠨᠡᠯᠡᠭᠡᠨᠢ ᠨᠡᠮᠡᠭᠳᠡᠯ	Нийт дүн
2020 оны 12 сарын 31 үлдэгдэл	559,377,218.00	50,346,312.00	-132,772,445.13	476,951,084.87
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			0.00	0.00
Залруулсан үлдэгдэл	559,377,218.00	50,346,312.00	-132,772,445.13	476,951,084.87
Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал/			37,185,709.93	37,185,709.93
Бусад дэлгэрэнгүй орлого		0.00		0.00
Өмчид гарсан өөрчлөлт	0.00			0.00
Зарласан ногдол ашиг			0.00	0.00

Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		0.00		0.00
2021 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	559,377,218.00	50,346,312.00	-95,586,735.20	514,136,794.80

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Тайлант он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	
1.1	<u>Мөнгөн орлогын дүн (+)</u>	265,986,555.06
	1.1.1 Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	265,986,555.06
	1.1.2 Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	0.00
	1.1.3 Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	0.00
	1.1.4 Буцаан авсан албан татвар	0.00
	1.1.5 Татаас, санхүүжилтийн орлого	0.00
	1.1.6 Бусад мөнгөн орлого	0.00
1.2	<u>Мөнгөн зарлагын дүн (-)</u>	258,795,268.55
	1.2.1 Ажилчдад төлсөн	64,743,477.00
	1.2.2 Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	21,517,871.51
	1.2.3 Бараа материал худалдан авахад төлсөн	24,592,616.17
	1.2.4 Ашиглалтын зардалд төлсөн	27,161,185.72
	1.2.5 Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	80,255,396.00
	1.2.6 Хүүгийн төлбөрт төлсөн	1,724,529.70
	1.2.7 Татварын байгууллагад төлсөн	25,972,115.38
	1.2.8 Даатгалын төлбөрт төлсөн	0.00
	1.2.8 Бусад мөнгөн зарлага	12,828,077.07
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	7,191,286.51
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	
2.1	<u>Мөнгөн орлогын дүн (+)</u>	7,902,739.72
	2.1.1 Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	0.00
	2.1.2 Биет бус хөрөнгө борлуулсны орлого	0.00
	2.1.3 Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	0.00
	2.1.4 Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	0.00
	2.1.5 Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	300,000.00
	2.1.6 Хүлээн авсан хүүгийн орлого	7,602,739.72
	2.1.7 Хүлээн авсан ногдол ашиг	0.00
2.2	<u>Мөнгөн зарлагын дүн (-)</u>	13,800,000.00
	2.2.1 Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө	13,800,000.00
	2.2.2 Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө	0.00
	2.2.3 Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн мөнгө	0.00
	2.2.4 Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө	0.00
	2.2.5 Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	0.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	-5,897,260.28
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	
3.1	<u>Мөнгөн орлогын дүн (+)</u>	15,584,388.00
	3.1.1 Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	15,584,388.00
	3.1.2 Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	0.00

	3.1.3 Төрөл бүрийн хандив	0.00
	3.1.4 Ханшны зөрүүний олз	0.00
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	30,000,000.00
	3.2.1 Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	30,000,000.00
	3.2.2 Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	0.00
	3.2.3 Хувьцаа буцаан авахад төлсөн	0.00
	3.2.4 Төлсөн ногдол ашиг	0.00
	3.2.5 Ханшны зөрүүний гарз	0.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-14,415,612.00
4	Валютын ханшийн зөрүү	0.00
4.1	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-13,121,585.77
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	91,578,182.30
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	78,456,596.53

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хайлааст голомт ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад НӨАТ-ын баримт, богино хугацаат өр төлбөр, дотоод хяналт, шилэн данстай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Э.Алтансүх гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Даваа, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Хайлааст голомт ОНӨААТҮГ 2021 оны санхүүгийн тайланг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн 01 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хайлааст голомт ОНӨААТҮГ нь Сүхбаатар сумын албан байгууллага, айл өрхийг дулаанаар хангах үндсэн үйл үйл ажиллагаагаа дулаан үйлдвэрлэх, түгээх, хангах тусгай зөвшөөрлийн хүрээнд явуулдаг байна. Сүхбаатар аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн 2021 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн А/21 дүгээр тогтоолоор тусгай зөвшөөрлийг 5 жилийн хугацаатайгаар сунгасан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаанд өөрчлөлт орсон бөгөөд санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна. Тайланд онд Сүхбаатар сумын төв дээрх айл өрхийг ундны усаар хангах 2 худаг болон хог зөөвөр, ус зөөврийн автомашинуудыг сумын ЗДТГ-аас Хайлааст голомт ОНӨААТҮГ-т шилжүүлсэн байна.

ОНӨААТҮГ-ын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилтийн үр үр нөлөө дунд байна гэж үзсэн. Нягтлан бодох бүртгэлийн программ хангамжийн хувьд мөнгөн гүйлгээний тайланг алдаатай илэрхийлдэг, үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлээс ерөнхий журналд бичилт хийгддэггүй, гараас бичилт хийдэг, үндсэн хөрөнгийн орлого, зарлагын гүйлгээ хийхэд хүндрэлтэй зэрэг алдаа, дутагдалтай байна.

Тус ОНӨААТҮГ-ын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хайлааст голомт ОНӨААТҮГ 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 280,155.9 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 4,202.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 3,151.8 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Байгууллагын үйл ажиллагаа

Хайлааст голомт ОНӨААТҮГ-ын зорилго нь "Сумын дулаан хэрэглэгчдийн ажиллах, сурч, амьдрах таатай орчныг хангах"-д оршино. ОНӨААТҮГ-ын дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг "Сумын төвийн албан байгууллага, аж ахуйн нэгжийн байр, иргэдийн сууцыг дулаанаар хангах үйл ажиллагаа эрхэлнэ." гэж тодорхойлжээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар статустай байна. Өмчийн 100 хувийг орон нутаг эзэмшиж байна.

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Хайлааст голомт ОНӨААТҮГ нь Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2012 оны дугаар 05 тогтоолыг үндэслэн байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 2 дахь заалтын 4 дэх хэсэгт “орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих.” гэж заасантай нийцэж байна.

Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно.” гэж заасан байна. Энэ хүрээнд зуухны барилгыг хашаажуулж, хяналтын камер суурилуулах арга хэмжээ авсан байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3. “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх;”-д заасны дагуу чиг үүргийн давхардалгүй, захирал, нягтлан бодогч, механикч, засварчин, 8 галч, нийт 12 орон тоотой үйл ажиллагаагаа явуулж байна. Удирдлагын цалин хөлсийг 895.9 мянган төгрөгөөр тогтоосон байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

3.6 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Хайлааст голомт ОНӨААТҮГ-ын тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	91,578,182.30	78,456,596.53	-13,121,585.77
Дансны авлага	52,360,243.22	74,505,378.16	22,145,134.94
Татвар, НДШ-ийн авлага	4,188,806.61	901,809.98	-3,286,996.63
Бусад авлага	25,311,449.35	23,976,752.55	-1,334,696.80
Бараа материал	12,047,985.26	17,798,883.23	5,750,897.97
Үндсэн хөрөнгө	1,103,598,501.71	1,642,673,498.03	539,074,996.32
Нийт хөрөнгийн дүн	1,289,085,168.45	1,838,312,918.49	549,227,750.04
Богино хугацаат өр төлбөрийн дүн	812,134,083.58	1,324,176,123.69	512,042,040.11
Эздийн өмчийн дүн	476,951,084.87	514,136,794.80	37,185,709.93
Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	1,289,085,168.45	1,838,312,918.49	549,227,750.04

Кассад бэлэн мөнгөний үлдэгдэлгүй байна. Банк дахь мөнгөний үлдэгдэлд харилцах дансанд байгаа 27.4 сая төгрөг, хугацаатай хадгаламж 50.0 сая төгрөг, ахмадын сангийн харилцах дансанд 0.9 сая төгрөг байна.

Авлагын үлдэгдэлд борлуулалтын авлага 74.5 сая төгрөг, ААНОАТ-ын авлага 0.9 сая төгрөг, бусад авлага 24.0 сая төгрөгийг эзэлж байна.

Тайлант онд Сүхбаатар сумын ерөнхий боловсролын сургуулиас авах 56.1 сая төгрөгийн халаалтын авлага нь авлагын өсөлтөд голлон нөлөөлжээ.

ОНӨААТҮГ-ын нягтлан бодох бүртгэлийн программ нь авлагын үлдэгдлийн хугацаа, насжилтыг тооцдоггүй байна. Найдваргүй авлагын нөөц байгуулаагүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 17.8 сая төгрөг болж 5.8 сая төгрөгөөр өссөн нь сэлбэг хэрэгслийн худалдан авалтаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь дараах шалтгаантай байна. Үүнд: шинээр 34.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 545.5 сая төгрөгийн хөрөнгө, балансаас баланст шилжин ирсэн 22.7 сая төгрөгийн хөрөнгө тус тус нэмэгдсэн байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэлд 1,324.2 сая төгрөгийн өр төлбөр байна. Үүнээс 1,287.2 сая төгрөгийн өр төлбөр нь үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй хүлээн авсантай холбоотой урьдчилж орсон орлого дансны үлдэгдэл байна.

3.6 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Хайлааст голомт ОНӨААТҮГ нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Сүхбаатар сумын ИТХ-ын 2021 оны А/54 дүгээр тогтоолоор Хайлааст голомт ОНӨААТҮГ-ын 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг шинэчлэн баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 238.5 сая төгрөгөөр, нийт зардлыг 236.4 сая төгрөгөөр, 2.1 сая төгрөгийн ашигтай байхаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 8.5 сая төгрөгийг төлөвлөсөн байна. Сүхбаатар сумын ИТХ-ын 2021 оны А/54 дугаар тушаалаар Хайлааст голомт ОНӨААТҮГ-ын 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг 245.3 сая төгрөгөөр тодотгосон байна.

Гүйцэтгэлээр 325.2 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 288.0 сая төгрөгийн зардал гарган, 37.2 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 325.2 сая төгрөг болж төлөвлөснөөс 79.9 сая төгрөг буюу 32.5 хувиар давсан байна. Үүнд үнэ төлбөргүй шилжин ирсэн үндсэн хөрөнгийг урьдчилж орсон орлого дансанд бүртгэж, улмаар тухайн хөрөнгийн тайлант үеийн элэгдлийн зардалтай тэнцэх хэмжээгээр урьдчилж орсон орлого дансыг бууруулах бичилт хийж, тайлант үеийн бусад орлогоор 48.2 сая төгрөгийг хүлээн зөвшөөрч бүртгэсэн, дулааны хэрэглэгч нэмэгдсэн зэрэг нь голлон нөлөөлсөн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 288.0 сая төгрөг болж, төлөвлөснөөс 42.7 сая төгрөг буюу 17.4 хувиар илүү гүйцэтгэлтэй байна. Энэ нь тайлант оны зардлын төлөвлөгөөг батлахдаа өмнөх оны 271.7 сая төгрөгийн зардлын гүйцэтгэлээс 28.5 сая төгрөгөөр бууруулж баталсан, байгууллагын үндсэн хөрөнгө нэмэгдсэнтэй холбоотойгоор 25.4 сая төгрөгийн элэгдлийн зардлын өсөлт зэрэг нь гол нөлөө үзүүлсэн байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу зуухны хашаа барих болон аваарын мотор, блокийн машин худалдан авахад өөрийн эх үүсвэрээс 34.5 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна.

Тайлант онд цэвэр ашиг 37.2 сая төгрөг болж, төлөвлөснөөс 35.1 сая төгрөгөөр илүү байгаа нь хэрэглэгч нэмэгдэж, зардал хэмнэх бодлого баримталсан нь нөлөөлж байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал байхгүй.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу Хайлааст голомт ОНӨААТҮГ-ын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 142 мэдээллээс 33 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Шилэн дансны цахим хуудсанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх онд 1 албан шаардлага, 2 зөвлөмж өгсөн байна. Үүнээс 1 албан шаардлага, 1 зөвлөмж хэрэгжиж, 1 зөвлөмж бүрэн хэрэгжээгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Хайлааст голомт ОНӨААТҮГ-ын санхүүгийн программын хувьд мөнгөн гүйлгээн тайлангийн санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээг алдаатай илэрхийлдэг, үндсэн хөрөнгө болон бараа материалын дэлгэрэнгүй бүртгэл болон ерөнхий журнал уялдаагүй, ерөнхий журнал дахь дебет, кредит ажил гүйлгээний дансны дугаар харагддаггүй зэрэг алдаа, дутагдалтай байгаа тул санхүүгийн программ хангамж солих шаардлага үүссэн байна. Иймд санхүүгийн шинэ программд санхүүгийн тайлан, бараа материал, үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй мэдээллийг үнэн зөв шивж оруулсан эсэхийг анхаарах шаардлагатай.

"Орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын үйл ажиллагааны үр дүн" сэдэвт гүйцэтгэлийн аудитаар ОНӨААТҮГ-уудад "Босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахдаа ТБОНӨХБАҮХАТХ-ийн дагуу тендер сонгон шалгаруулалт зарлаж байх." гэсэн зөвлөмж хүргүүлсэн тул энэхүү зөвлөмжийн хэрэгжилтийг дараагийн аудитаар анхаарах шаардлагатай.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1.1 сая төгрөгийн алдаа зөрчил илэрсэнд 4 зөвлөмж өгсөн. Эдгээр зөвлөмж нь богино хугацаат өр төлбөр, зардал, дотоод хяналт, шилэн данстай холбоотой байна.

4.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1 Богино хугацаат өр төлбөртэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Санхүүгийн тайланд татварын авлага 1,866.8 мянган төгрөг, татварын өглөг 274.3 мянган төгрөгөөр тайлагнасан байхад татварын байгууллагын тодорхойлолтоор 3 нэр төрлийн татвар 7,766.1 мянган төгрөгийн илүү төлөлттэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.2.1 дэх заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Татварын байгууллагын тодорхойлолт дахь татварын илүү, дутуу төлөлтийг татварын байгууллагатай тооцоо нийлж, санхүүгийн тайланд үнэн зөв тайлагнах.

2 Зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант онд 1,115.1 мянган төгрөгийн НӨАТ ногдох 12,266.5 мянган төгрөгийн тээврийн хөлсийг Шаргын хурд ХХК-нд шилжүүлсэн боловч НӨАТ-ын баримт татварын цахим системд шивээгдээгүй байна. Энэ нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.2 дахь заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Бараа, ажил, үйлчилгээний худалдан авалт хийхдээ НӨАТ-ын баримтыг бэлтгэн нийлүүлэгч байгууллага татварын цахим системд шивсэн тохиолдолд төлбөрийн гүйлгээг хийж байх, НӨАТ-ын тухай хууль, тогтоомжийг мөрдөж ажиллах.

3 Дотоод хяналттай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Хайлааст голомт ОНӨААТҮГ-ын санхүүгийн программын хувьд мөнгөн гүйлгээн тайлангийн санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээг алдаатай илэрхийлдэг, үндсэн хөрөнгө болон бараа материалын дэлгэрэнгүй бүртгэл болон ерөнхий журнал уялдаагүй, ерөнхий журнал дахь дебет, кредит ажил гүйлгээний дансны дугаар харагддаггүй, авлагын хугацаа, насжилтыг тооцоолдоггүй зэрэг алдаа, дутагдалтай байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн

тухай хуулийн 20.2.4-д заасан нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтыг хэрэгжүүлэхэд хүндрэл үүсгэдэг байна.

Өгсөн зөвлөмж:

Санхүүгийн тайланг алдаагүй илэрхийлдэг, нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтыг хэрэгжүүлэхэд тохиромжтой санхүүгийн программ хангамжтай болох.

4 Шилэн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 142 мэдээллээс 33 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-тай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг хуульд заасан хугацаанд мэдээлж, Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ыг мөрдөж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
	Хайлааст голомт ОНӨААТҮГ	3	1.1	0	0	0	0	0	0	3	0
	Дүн	3	1.1	0	0	0	0	0	0	3	0
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
	Хайлааст голомт ОНӨААТҮГ	1	0	0	0	0	0	0	0	1	0
	Дүн	1	0	0	0	0	0	0	0	1	0
	Нийт дүн	4	1.1	0	0	0	0	0	0	4	0